



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ

2021 оны 11 сарын 11 өдөр

Дугаар 484

Улаанбаатар хот

Хариуцлага тооцох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 131 дүгээр зүйлийн 131.1.1 дэх хэсэг, Төрийн өмчтэй үйлдвэрийн газрын захиралтай байгуулсан контрактын 3 дугаар зүйлийн 3.2.12 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.2 дахь хэсэг, Авлигатай тэмцэх газрын 2021 оны 06/11194 тоот албан бичгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчтэй үйлдвэрийн газрын захирал Э.Цогтгэрэл нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, 8 дугаар зүйлийн 8.1, 8.1.1 дэх хэсэг, 33 дугаар зүйлийн 33.1, 33.2, 33.2.1 дэх хэсгийг тус тус зөрчиж бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг явуулсан тул албан тушаалын цалингийн хэмжээг нэг сарын хугацаатай 20 хувиар бууруулах арга хэмжээ авсугай.

2. Цаашид Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль тогтоомжийг мөрдлөг болгон, дээрх төрлийн зөрчлийг дахин гаргахгүй ажиллахыг “Мэдээлэл технологийн үндэсний парк” төрийн өмчтэй үйлдвэрийн газрын захирал Э.Цогтгэрэлд үүрэг болгосугай.

3. Энэхүү тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-д даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ

132001436